

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
ГАЗАР



**САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

Эрдэнэмандал сумын ТЕЗ-ийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** АРА-2021/7/СТА-ТТЗ

**Хаяг:** Архангай аймаг,  
Эрдэнэбулган сум. Аймгийн  
ЗДТГ-ын байр “А” корпус, 3  
давхар зүүн жигүүр.

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

2021 он

Дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Д.Уламбаяр

Утас: 70333141

Цахим хаяг: [ulambayard@audit.gov.mn](mailto:ulambayard@audit.gov.mn)

Аудитын менежер: Т.Байгалмаа

Утас: 70332860

Цахим хаяг: [baigalmaat@audit.gov.mn](mailto:baigalmaat@audit.gov.mn)

Аудитор: П.Энхжаргал

Утас: 99743112

Цахим хаяг: [enkhjargal@audit.gov.mn](mailto:enkhjargal@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	8
3. Аудитын тайлан .....	9
3.1. Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	9
3.4 Материаллаг байдал .....	9
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт .....	10
3.5.1 Мөнгөн хөрөнгө .....	10
3.5.2 Авлага.....	10
3.5.6 Бараа материал .....	11
3.5.7 Үндсэн хөрөнгө.....	11
3.5.8 Өр төлбөр.....	12
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо.....	12
3.5.10 Орлогын данс.....	12
3.5.11 Зардлын данс.....	13
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	13
3.7 Шилэн дансны мэдээлэл .....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	16
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	17
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	18
4. Менежментийн захидал.....	18
1.1. Орлогын данстай холбоотой асуудал.....	18
2.2 Балансын данстай холбоотой асуудал.....	18
3.3 Шилэн данстай холбоотой асуудал .....	
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	20

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч

## 1. Аудитын гэрчилгээ

 <b>АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</b> 65130 Цэцэрлэг, Архангай аймаг Утас/Факс: 976-70333141 И-мэйл: arkhangai@audit.gov.mn	<b>ЭРДЭНЭМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА Н.ЛХАГВАДОРЖ ТАНАА</b>
<u>2021. 03. 31</u> № <u>144</u> танай _____ -ны № _____ -г	
<b>АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ</b>	
<b>Зөрчилгүй дүгнэлт</b>	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Эрдэнэмандал сумын ТЭЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p>	
<p>Эрдэнэмандал сумын ТЭЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.</p>	
<b>Дүгнэлтийн үндэслэл</b>	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
<b>Бусад мэдээлэл</b>	
<p>Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 21 зорилтын хүрээнд 100 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 87.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.</p>	
<p>Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.</p>	
<b>Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага</b>	
<p>Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.</p>	
<p>Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.</p>	

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.УЛАМБАЯР

## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	786,977.6	982,339.6
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	292,674.5	326,200.3
33	<b>АВЛАГА</b>	284,125.7	318,830.1
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	210,177.4	337,309.1
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	11,111,956.2	11,287,252.5
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	11,111,956.2	11,287,252.5
39200	Биет хөрөнгө	10,951,490.2	11,112,530.6
39300	Биет бус хөрөнгө	160,466.0	174,721.9
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	11,898,933.8	12,269,592.1
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	15,710.4	15,710.4
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	15,710.4	15,710.4
41400	Урьдчилж орсон орлого	15,710.4	15,710.4
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	11,883,223.4	12,253,881.7
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	11,883,223.4	12,253,881.7
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,041,819.3	3,056,075.1
51200	Хуримтлагдсан үр дүн	7,027,585.2	7,389,479.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,813,819.0	1,808,327.5
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	11,898,933.8	12,269,592.1

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	5,009,757.4	3,809,655.20
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	177,705.7	231,285.6
110	Орлогын албан татвар	131,167.0	168,919.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	131,167.0	168,919.3
113	Хөрөнгийн албан татвар	4,470.0	6,374.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	42,068.7	55,992.3
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	1,839,793.3	684,312.2
120	Нийтлэг татварын бус орлого	1,839,793.3	684,312.2
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	2,992,258.4	2,894,057.30
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	3,432,176.5	3,322,051.30
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	3,432,176.5	3,322,051.30
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,796,231.0	3,179,347.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,669,331.2	2,037,249.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	228,072.2	239,721.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	113,896.5	195,742.5
2104	Хангамж, бараа материалын зардал	66,671.0	90,145.9
2105	Нормативт зардал	190,468.4	122,115.7

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,337.5	11,000.0
2107	Томилолт, зочны зардал	11,026.8	6,667.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,377.2	13,634.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	494,050.3	463,070.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	635,945.4	142,703.80
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,577,580.9	487,603.80
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	176,131.5	131,201.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,401,449.4	356,402.4

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,272,516.1	3,271,329.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	177,705.7	231,285.6
110	Орлогын албан татвар	131,167.0	168,919.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	131,167.0	168,919.3
113	Хөрөнгийн албан татвар	4,470.0	6,374.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	42,068.7	55,992.3
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	17,869.1	26,103.1
1181	Газрын төлбөр	0.0	4,157.3
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	24,199.6	25,731.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	102,552.0	145,986.4
120	Нийтлэг татварын бус орлого	102,552.0	145,986.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,992,258.4	2,894,057.3
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,988,578.0	2,960,357.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,988,578.0	2,960,357.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,352,509.1	2,816,755.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,682,029.7	2,008,539.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	210,249.5	266,867.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	112,181.8	199,783.5
2104	Хангамж, бараа материалын зардал	58,752.2	79,767.0
2105	Нормативт зардал	188,540.2	120,749.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,132.8	25,760.1
2107	Томилолт, зочны зардал	12,558.4	7,065.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,248.4	23,284.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,816.1	84,939.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	636,068.9	143,601.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	283,938.1	310,971.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	183,443.3	127,445.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	183,443.3	127,445.8

2200	Дотоод эх үүсвэрээр	183,443.3	127,445.8
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-183,443.3	-127,445.8
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-46,000.0	-150,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	46,000.0	150,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	54,494.8	33,525.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	238,179.8	292,674.5
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	292,674.5	326,200.3

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,041,819.3	1,817,681.9	5,622,272.8	10,481,774.0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	-396.6	3,862.9	3,466.3
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,041,819.3	1,817,285.3	5,626,135.8	10,485,240.3
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-3,466.3	0.00	-3,466.3
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,401,449.4	1,401,449.4
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,041,819.3	1,813,819.0	7,027,585.2	11,883,223.4
11	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,041,819.3	1,813,819.0	7,027,585.2	11,883,223.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,041,819.3	1,813,819.0	7,027,585.2	11,883,223.4
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-5,491.5	5,491.5	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	14,255.9	0.00	0.00	14,255.9
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	356,402.4	356,402.4
20	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,056,075.1	1,808,327.5	7,389,479.0	12,253,881.7

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,359,924.4	3,136,086.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,943,766.8	2,880,386.2

210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,833,355.6</b>	<b>2,777,763.8</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,008,539.5</b>	<b>2,008,539.5</b>
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>271,123.3</b>	<b>266,867.4</b>
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>199,783.5</b>	<b>199,783.5</b>
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>63,588.5</b>	<b>62,926.8</b>
2105	<b>Нормативт зардал</b>	<b>165,035.5</b>	<b>120,749.1</b>
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>39,000.0</b>	<b>37,100.0</b>
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>9,299.6</b>	<b>7,065.6</b>
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>18,529.3</b>	<b>18,362.6</b>
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>58,456.4</b>	<b>56,369.3</b>
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>110,411.2</b>	<b>102,622.4</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>110,411.2</b>	<b>102,622.4</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>182,357.6</b>	<b>105,700.6</b>
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>233,800.0</b>	<b>150,000.0</b>
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,359,924.4</b>	<b>3,141,863.4</b>
31	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,097,753.2</b>	<b>2,045,816.7</b>
32	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>900,619.1</b>	<b>964,680.6</b>
35	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>361,552.1</b>	<b>131,366.1</b>
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	<b>202,916.0</b>
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	<b>208,692.5</b>
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>7</b>	<b>7</b>
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>179</b>	<b>179</b>

#### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>60737.2</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>60737.2</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>60737.2</b>
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>17315.5</b>
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4000.0</b>
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4921.7</b>
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>34500.0</b>
I	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>60737.2</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>60737.2</b>

### **3. Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Эрдэнэмандал сумын ТЭЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч Н.Лхагвадорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидлаар хүргүүлдэг.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 14-аас 2021 оны 03 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Энхжаргал гүйцэтгэв.

Эрдэнэмандал сумын ТЭЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 1/71 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Эрдэнэмандал сумын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Төрийн бодлого шийдвэр, үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх, сумын тогтвортой хөгжлийг хангахад Засаг даргад бүх талын дэмжлэг үзүүлэх, нутгийн захиргааны манлайллыг дээшлүүлэх замаар иргэдэд төрийн чанартай үйлчилгээг үзүүлэх талаар үр нөлөөтэй үйл ажиллагаа явуулдаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн, байнга суралцагч мэргэшсэн тогтвортой, санаачилгатай цомхон чадварлаг алба байхад оршино” дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Эрдэнэмандал сум нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд төсвийн 8 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэж нэгтгэлийг онлайн-аар бэлтгэж байна. Хашаат сумын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад үр нөлөөтэй байлаа.

#### **3.4 Материаллаг байдал**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 1,973,993.5 мянган төгрөгийн 1 хувь буюу 19,739.9 мянган төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 4,018,439.6 мянган төгрөгийн 1 хувь буюу 40,184.4 мянган төгрөгөөр тогтоов.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 292,674.5 мянга, эцсийн үлдэгдэл 326,200.3 мянган төгрөг болж, 33,525.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн сангийн харилцах	292,674.5	326,200.3	33,525.8
<b>Дүн</b>	<b>292,674.5</b>	<b>326,200.3</b>	<b>33,525.8</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр:</b>			
Сум хөгжүүлэх сан	153,482.1	132,035.5	-21,446.6
Орон нутгийн ерөнхий орлого	89,758.6	117,507.8	27,749.2
Орон нутгийн хөгжлийн сан	49,433.8	76,657.0	27,223.2
<b>НИЙТ МӨНГӨН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>292,674.5</b>	<b>326,200.3</b>	<b>33,525.8</b>

Эх сурвалж: Эрдэнэмандал сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт мөнгөн хөрөнгийн 36 хувь буюу 117,507.8 мянган төгрөг нь орон нутгийн ерөнхий орлогын дансны, 23.5 хувь буюу 76,657.0 мянган төгрөг нь ОНХСангийн, 40.5 хувь буюу 132,035.5 мянган төгрөг нь сум хөгжүүлэх сангийн дансны үлдэгдэл байна.

#### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 284,125.7 мянга, эцсийн үлдэгдэл 318,830.1 мянган төгрөг болж, 34,704.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Зээлийн авлага	284,125.7	316,377.4	32,251.7
Ахлах сургууль		479.8	479.8
Соёлын төв		1,972.9	1,972.9
<b>Дүн</b>	<b>284,125.7</b>	<b>318,830.1</b>	<b>34,704.4</b>

Эх сурвалж: Эрдэнэмандал сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын төсөвт байгууллагууд авлагын үлдэгдэлгүй бөгөөд СХС-ийн үлдэгдэл 316,377.4 мянган төгрөг байна.

СХСангийн авлагыг зээлийн ангиллаар авч үзвэл 38 хүнтэй холбоотой 211,000.0 мянган төгрөг буюу 66.7 хувь нь хугацаандаа төлөгдөж байгаа хэвийн зээл, 11 хүнтэй холбоотой 105,377.4 мянган төгрөгийн буюу 33.3 хувь нь хугацаа хэтэрсэн зээл байна.

**Аудитын илрүүлэлт:** Сум хөгжүүлэх сангаас олгосон 105,377.4 мянган төгрөгийн 11 зээлдэгчтэй холбоотой хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Засгийн газрын 2016 оны 153-р тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмыг зөрчсөн байна.

### 3.5.6 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 210,177.4 мянга, эцсийн үлдэгдэл 337,309.1 мянган төгрөг болж, 127,131.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Эм боох материал	283.7	797	513.3
Бичиг хэргийн материал	2,586.50	4,987.10	2,400.60
Аж ахуйн материал	153,155.00	248,847.90	95,692.90
Түлш, шатах тослох материал	206.7	670.7	464
Барилгын засварын материал	1,066.80	1,991.00	924.3
Хүнсний материал	2,697.30	-	-2,697.30
Бусад хангамжийн материал	13,280.60	42,780.60	29,500.00
Мал амьтад	36,901.00	37,235.00	334
<b>Дүн</b>	<b>210,177.40</b>	<b>337,309.10</b>	<b>127,131.70</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>			
Ахлах сургууль	90,560.20	155,557.30	64,997.10
Хүүхдийн цэцэрлэг	55,691.00	80,912.00	25,221.10
Соёлын төв	13,963.50	13,934.70	-28.8
Засаг даргын тамгын газар	48,536.40	85,378.70	36,842.30
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1,426.40	1,526.40	100
<b>Дүн</b>	<b>210,177.40</b>	<b>337,309.10</b>	<b>127,131.70</b>

Эх сурвалж: Эрдэнэмандал сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл нийт дүнгээр 127,131.7 мянган төгрөгөөр өссөн боловч нэр төрлөөр авч үзвэл түүхий эд материал 513.3 мянган төгрөгөөр, хангамжийн материал 126,284.4 мянган төгрөгөөр тус тус өссөн байна. Мөн тайлант онд 334.0 мянган төгрөгийн малын нас дэвшилт хийгдсэн байна.

Нийт бараа материалын 46.1 хувь буюу 155,557.3 мянган төгрөг нь ахлах сургуулийн, 25.3 хувь буюу 85,378.7 мянган төгрөг нь ЗДТГ-ын, 24.0 хувь буюу 80,912.0 мянган төгрөг нь Хүүхдийн цэцэрлэгийн, 4.1 хувь буюу 13,934.7 мянган төгрөг нь Соёлын төвийн, 0.5 хувь буюу 1,526.4 мянган төгрөг нь ИТХ-ийн бараа материал байна.

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 11,111,956.2 мянга, эцсийн үлдэгдэл 11,287,252.5 мянган төгрөг болж, 175,296.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	10,951,490.2	11,112,530.6	161,040.4
Биет бус хөрөнгө	160,466.0	174,721.9	14,255.9
<b>Дүн</b>	<b>11,111,956.2</b>	<b>11,287,252.5</b>	<b>175,296.3</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>			
Ахлах сургууль	6,854,157.8	6,707,828.8	-146,329.0
ЗДТГ	1,705,496.2	1,669,987.2	-35,509.0
ИТХ	431,045.6	570,194.5	139,148.9
Соёлын төв	2,120,970.2	2,335,166.1	214,195.9
Хүүхдийн цэцэрлэг	286.5	4,075.9	3,789.5
<b>Дүн</b>	<b>11,111,956.2</b>	<b>11,287,252.5</b>	<b>175,296.3</b>

Эх сурвалж: Эрдэнэмандал сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 21,745.2 мянга, үнэ төлбөргүй хандиваар авсан 147,261.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн, шилжүүлэн авсан 445,935.4 мянган төгрөгөөр, акталсан 132,635.1 мянган төгрөгөөр хасагдсан байна. Тайлант онд нийт 309,988.8 мянган төгрөгийн элэгдэл тооцогдсноос акталсан хөрөнгийн 2,978.7 мянган төгрөгийн элэгдэл хасагдаад нийт 307,010.1 мянган төгрөгийн элэгдлийн зардал гарсан байна.

- Ахлах сургууль- Элэгдлээ бүрэн нөхсөн 185ш хөрөнгө байгааг өмч хамгаалал байнгын зөвлөлөөрөө хэлэлцүүлэн цаашид ашиглагдах боломжит хугацаа болон холбогдох нөхцөлийг хэлэлцүүлээгүй хөрөнгө байна.

### 3.5.8 Өр төлбөр

Орон нутгийн ерөнхий орлогын 15,710.4 мянган төгрөгийн өглөгтэй байна.

Хүснэгт № 5 Өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Бусад урьдчилж орсон орлого	15,710.4	15,710.4	-
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Орон нутгийн ерөнхий орлого	15,710.4	15,710.4	-
<b>ДҮН</b>	<b>15,710.4</b>	<b>15,710.4</b>	<b>-</b>

Эх сурвалж: Эрдэнэмандал сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөр буюу урьдчилж орсон орлогын үлдэгдэл 15,710.4 мянган төгрөг байна. Энэ нь өмнөх онд татварын цахим систем шинэчлэгдсэнтэй холбогдон данс андуурч орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрсөн мөнгө бөгөөд тайланд урьчилж орсон орлогоор бүртгэсэн байна.

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 11,883,223.5 мянга, эцсийн үлдэгдэл 12,253,881.7 мянган төгрөг болж, 370,658.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 5. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,041,819.3	3,056,075.1	14,255.8
<b>Засгийн газрын оруулсан капитал</b>	3,041,819.3	3,056,075.1	14,255.8
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	7,027,585.2	7,389,555.2	361,970.0
<b>Өмнөх үеийн үр дүн</b>	5,626,135.8	7,033,152.8	1,407,017.0
<b>Тайлант үеийн үр дүн</b>	1,401,449.4	356,402.4	-1,045,047.0
<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>	1,813,819.0	1,808,251.4	-5,567.6
<b>Дүн</b>	<b>11,883,223.5</b>	<b>12,253,881.7</b>	<b>370,658.2</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
<b>Төсөвт байгууллага</b>	11,396,181.8	11,728,811.8	332,630.0
<b>Төсөл, сан</b>	487,041.7	525,069.9	38,028.2
<b>Дүн</b>	<b>11,883,223.5</b>	<b>12,253,881.7</b>	<b>370,658.2</b>

Эх сурвалж: Эрдэнэмандал сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 12,253,881.7 мянган төгрөг болж 370,658.2 мянган төгрөгөөр өссөн нь хуримтлагдсан үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5.10 Орлогын данс

Эрдэнэмандал сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангаар 3,809,655.2 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлогыг тайлагнасан нь өмнөх оноос

1,200,102.2 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 575,173.5 мянган төгрөгийн устгах бичилт хийгдсэн байна. Үр дүнгийн тайлангийн нийт орлогыг задалбал:

- Татварын орлого 231,285.6 мянган төгрөг,
- Татварын бус орлого 684,312.2 мянган төгрөг байна. Үүнээс: Хүү торгуулийн орлого 14,311.2 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 13,617.8 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 656,074.2 мянган төгрөг, бусад орлог 309.0 мянган төгрөг байна.
- Тусламж санхүүжилтийн орлого 2,894,057.3 мянган төгрөг байна. Үүнээс: улсын төсвөөс 2,086,796.2 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансаар 60,737.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 746,523.9 мянган төгрөг байна.

### 3.5.11 Зардлын данс

Эрдэнэмандал сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны зардал 3,322,051.3 мянган төгрөг, үйл ажиллагааны бус зардал 131,201.5 мянган төгрөг, нийт 3,453,252.8 мянган төгрөгийн зардал тайлагнагдаж тайлант үеийн үр дүн өмнөх оноос 356,402.4 мянган болж өссөн нь үнэ төлбөргүй хандив тусламжаар хүлээн авсан хөрөнгөөс шалтгаалсан байна. Тайлант жилд 575,173.5 мянган төгрөгийн давхардсан гүйлгээг устгах бичилт хийж тайлагнасан байна.

#### Аудитын илрүүлэлт:

- ИТХ-ын цалингийн цэснээс түүвэрлэн 1, 2, 3, 4, 12 сарын цалинг давтан тооцоход албан хаагчдын НДШ, ХХОАТ-ын хөнгөлөлтийг 1-6.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тооцож олгосон.
- ЗДТГ-ын цалингийн цэснээс түүвэрлэн 1, 10, 11, 12 сарын цалинг давтан тооцоход давхардсанаар 29 албан хаагчдын ХХОАТ-ын хөнгөлөлтийг зөрүүтэй тооцож олгосон.
- Хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны цалингаас түүвэрлэн 1, 2, 10, 11, 12 сарыг тулган шалгахад 1 сарын цалинг тооцож олгоходоо тушаалаар тогтоосон цалингийн шатлалыг 41.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тооцож олгосон зөрчил илэрсэн.
- Ахлах сургууль- Нийт ажил гүйлгээнээс түүвэрлэн үзэхэд цахим төлбөрийн баримтаар баталгаажаагүй 162,885.7 мянган төгрөгийн анхан шатны баримтаар гүйлгээ хийсэн байна.

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Орон нутгийн төсвийн орлогыг 102,007.0 мянган төгрөгөөр анх төсөвлөж холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлснийг 14,640.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 116,647.1 мянган төгрөгөөр анх баталсан байна.

Эрдэнэмандал сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 4 дугаар тогтоолоор тухайн сум тайлант онд 154,265.2 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 246,075.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 59.5 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 6. Сумын орон нутгийн төсвийн орлого

/мянган төгрөг/

Үзүүлэлтийн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
<b>1.НИЙТ ОРЛОГО</b>	154,265.2	246,075.9	91,810.7	159.5
<b>2.УРСГАЛ ОРЛОГО</b>	154,265.2	246,075.9	91,810.7	159.5
<b>3.ТАТВАРЫН ОРЛОГО</b>	151,395.2	231,285.6	79,890.4	152.8
<b>4.Орлогын албан татвар</b>	101,190.0	168,919.3	67,729.3	166.9
Хүн амын орлогын албан татвар	101,190.0	168,919.3	67,729.3	166.9
Үйл ажиллагааны орлого	3,500.0	4,682.2	1,182.2	133.8
Хөрөнгийн орлого	52,800.0	77,354.9	24,554.9	146.5
Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого	150.0	230.0	80.0	153.3
Шууд бус орлого	44,740.0	86,652.2	41,912.2	193.7
<b>Өмчийн татвар</b>	<b>5,490.0</b>	<b>6,374.0</b>	884.0	116.1
Үл хөдлөх хөрөнгийн татвар			-	
Бууны албан татвар	5,490.0	6,374.0	884.0	116.1
Бусад татвар	<b>18,706.0</b>	<b>30,260.4</b>	11,554.4	161.8
Улсын тэмдэгтийн хураамж	3,300.0	5,617.6	2,317.6	170.2
Газрын төлбөр:	2216.0	4,157.3	1,941.3	187.6
Газрын төлбөр		57.3	57.3	
Газрын дуудлага худалдааны орлого	2216.0	4,100.0	1,884.0	185.0
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны	1390.0	8,084.6	6,694.6	581.6
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	11,800.0	12,400.9	600.9	105.1
<b>Байгалийн нөөц ашигласны төлбөр:</b>	<b>26,009.20</b>	<b>25,731.9</b>	(277.3)	98.9
Байгалийн ургамал ашигласны төлбөр			-	
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	300.0	851.0	551.0	283.7
Ойн нөөц ашигласны төлбөр	25,623.2	24,780.9	(842.3)	96.7
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	86.0	100.0	14.0	116.3
<b>5.ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,870.00</b>	<b>14,790.3</b>	11,920.3	515.3
Төсөвт газрын өөрийн орлого	170	170.0	-	100.0
Хүү, торгуулийн орлого	1200	14,311.3	13,111.3	1,192.6
Нэр заагдаагүй бусад орлого	1500	309.0	(1,191.0)	20.6

Аудитын илрүүлэлт: Орлого нийт дүнгээрээ давж биелсэн боловч 2 нэр төрлийн орлого 2,033.3 мянган төгрөгөөр тасарсан байна. Үүнд:

1. Ойн нөөц ашигласны төлбөр 842.3 мянган төгрөгөөр,
2. Нэр заагдаагүй бусад орлого 1,191.0 мянган төгрөгөөр,

Энэ нь төсвийн тухай хуулийн 41.2.1 “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

### Төсвийн төлөвлөлт

Эрдэнэмандал сумын ИТХ-ын 2020 оны төсөв батлах тогтоолоор сумын нийт орлого, санхүүгийн дэмжлэг, төсөвт байгууллагуудад олгох санхүүжилтийг 3,440,382.2 мянган төгрөгөөр анх баталсан бол тодотгосон тогтоолоор 3,326,724.4 мянган төгрөг болж 113,657.8 мянган төгрөгөөр бууруулсан байна.

Хүснэгт 7. Сумын төсвийн төлөвлөлт

/мянган төгрөг/

№	Байгууллага, орлогын нэр төрөл	Анх баталсан дүн	Тодотгон баталсан дүн	Зөрүү
1	Сумын төсвийн татварын орлого	113,636.0	154,265.2	40,629.2
2	ТЕЗ-ийн харьяа байгууллагын төвлөрүүлэх орлого	238,070.0	237,900.0	-170.0
3	Аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	388,918.6	337,043.4	-51,875.2
4	ОНХС-ийн орлогын шилжүүлэг	137,568.3	132,923.7	-4,644.6
5	СӨБ-ийн үйлчилгээ	606,750.6	557,061.5	-49,689.1
6	ЕБС-ийн үйлчилгээ	1,771,539.0	1,686,615.2	-84,923.8
7	Соёлын үйлчилгээ	89,934.6	97,433.3	7,498.7
8	2019 оны ОН-ийн төсвийн үлдэгдлээс санхүүжих дүн	44,531.2	74,048.2	29,517.0
9	2020 оны ОНХС-ийн төсвийн үлдэгдлээс санхүүжих дүн	49,433.9	49,433.9	0.0
	<b>Нийт дүн</b>	<b>3,440,382.2</b>	<b>3,326,724.4</b>	<b>-113,657.8</b>
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	65,949.2	73,226.2	7,277.0
2	Засаг даргын тамгын газар	473,666.6	492,130.6	18,464.0
3	Орон нутгийн хөгжлийн сан	187,002.2	182,357.6	-4,644.6
4	Сум хөгжүүлэх сан	235,800.0	235,800.0	0.0
5	Сургуулийн өмнөх боловсрол	606,750.6	557,061.5	-49,689.1
6	Ерөнхий боловсролын сургууль	1,772,139.0	1,687,215.2	-84,923.8
7	Соёлын төв	99,074.6	98,933.3	-141.3
	<b>Нийт дүн</b>	<b>3,440,382.2</b>	<b>3,326,724.4</b>	<b>-113,657.8</b>

Тайлант онд төсвийн орлогын эхний хагас жилийн гүйцэтгэлийг үндэслэн зарим нэр төрлийн орлогыг нэмэгдүүлэн баталсан бол

1. Аймагт ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл цуцлагдаж орох орлого буурсан зэрэгтэй уялдуулан орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 4,644.6 мянган төгрөгөөр
2. Ковид-19 цар тахалтай холбогдуулан тусгай зориулалтын шилжүүлэгийн байгууллагын /сургууль, цэцэрлэг/ үйл ажиллагаа түр хаасантай холбоотойгоор тусгай зориулалтын шилжүүлгээс 134,612.9 мянган төгрөгөөр тус тус хасаж тодотгол хийгдсэн байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 12 хөтөлбөрт зориулан 3,326,724.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,943,766.8 мянган төгрөгийг урсгал зардалд, 182,357.6 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 233,800.0 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн зээлд зарцуулахаар батлагджээ.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 3,359,924.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 900,619.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 2,097,753.2 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлэгээс, 361,552.1 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Энэ нь аймгийн ИТХ-ын “Аймгийн 2020 оны төсөвт зохицуулалт хийж тодотгон батлах тухай” 2020 оны 12 сарын 13-ны өдрийн 04 тоот тогтоолоор Ахлах сургууль, Хүүхдийн цэцэрлэг зэрэг байгууллагуудыг 33,200.0 мянган төгрөгөөр бууруулж сумын нийт зардлыг 3,359,924.4 мянган төгрөгөөр баталсан нь ковид-19 цар тахлын улмаас хэмнэгдэж байгаа сургуулийн хүүхдийн үдийн хоол, цайны зардлын санхүүжилтээс Сангийн яам төсөвт зохицуулалт хийн буцаан татсантай холбоотой байна.

Харин төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,136,086.8 мянган төгрөг буюу 93.3 хувьтай байгаа нь урсгал зардлаас 63,380.6 мянган төгрөг, хөрөнгийн зардлаас 76,657.0 мянган төгрөг, сум хөгжүүлэх сангаас 83,800.0 мянган төгрөг хэмнэгдэж зарцуулаагүйтэй холбоотой байна.

Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 10 төсөл, арга хэмжээ 182,357.6 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас 5 арга хэмжээ бүрэн хэрэгжиж гүйцэтгэлээр 105,700.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 5 арга хэмжээ хэрэгжээгүйгээс 76,657.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 60,737.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж, бараа материалын зардалд 17,315.5 мянга, урсгал зардалд 4,000.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 4,921.7 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 34,500.0 мянга, нийт 60,737.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### 3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

#### Аудитын илрүүлэлт:

- ТЕЗ- Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 126 мэдээллээс 118 мэдээллийг хугацаанд нь, 8 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.
- Хүүхдийн цэцэрлэг- Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг тулган шалгахад шилэн дансны цахим хуудсанд дараа жилийн төсвийн төсөл, батлагдсан төсөв, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг байршуулаагүй, 9 мэдээллийг хугацаа хоцрооч мэдээлсэн.
- Соёлын төв- Шилэн дансны цахим системд Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг 23658,7 мянган төгрөгөөр, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 1885,4 мянган төгрөг, уран бүтээлийн зардлаас 400,0 төгрөгийн мэдээллүүдийг тус тус байршуулаагүй зөрчил илэрлээ.
- Ахлах сургууль- Шилэн дансны хуулийн дагуу 126 мэдээлэл оруулахаас 34 мэдээлэл хугацаа хоцроосон

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 184,025.7 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 8. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	1	184,025.7	1	78,648.3			42.7%
<b>Нийт</b>	<b>1</b>	<b>184,025.7</b>	<b>1</b>	<b>78,648.3</b>			<b>42.7%</b>

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар сум хөгжүүлэх сангаас олгосон 184,025.7 мянган төгрөгийн 19 зээлдэгчтэй холбоотой асуудалд зөвлөмж хүргүүлсэн нь тайлант онд 78,648.3 мянган төгрөгөөр буурсан тул зөвлөмжийн биелэлтийг 42.7% гэж үзлээ.

### 3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 5 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 7 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллага түүврээр хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан ЗДТГ, ИТХ, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, зэрэг байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлтийг өгсөн байна. Хүснэгтээр харуулвал:

Хүснэгт №9.Аудитын дүнгийн талаар:

Байгууллагын нэр	Байгууллагын тоо			Аудитын санал дүгнэлтийн төрөл	
	Хамрагдсан	Гүйцэтгэсэн		Бүгд	Үүнээс Зөрчилгүй
		Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан		
ИТХ	1	1		1	1
ЗДТГ	1	1		1	1
Хүүхдийн цэцэрлэг	1	1		1	1
Соёлын төв	1		1		
Ахлах сургууль	1	1		1	1
ОНХС	1		1		
СХС	1		1		
<b>НИЙТ ДҮН</b>	<b>7</b>	<b>4</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>4</b>

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 232,766.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 43,936.2 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 25,944.1 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 162,885.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 9 зөвлөмжийг хүргүүллээ.

Хүснэгт №10. Төсвийн шууд захирагчдын төлбөр зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчил		Залруулсан алдаа		Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
ИТХ	2				2				2	
ЗДТГ	2				2				2	
Хүүхдийн цэцэрлэг	3				3				3	
Соёлын төв	1	25,944.1			1	25,944.1	1	25,944.1		
Ахлах сургууль	5	206,821.9	2	43,936.2	3	162,885.7	1		2	162,885.7
<b>НИЙТ ДҮН</b>	<b>13</b>	<b>232,766.0</b>	<b>2</b>	<b>43,936.2</b>	<b>11</b>	<b>188,829.8</b>	<b>2</b>	<b>25,944.1</b>	<b>9</b>	<b>162,885.7</b>

Санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийгдээгүй.

Ахлах сургуулийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 36,818.1 мянган төгрөгөөр, үр дүнгийн тайлангийн ашиг өмчийн өөрчлөлтийн тайлангийн ашигтай 7,118.1 мянган төгрөгөөр нийт 43,936.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байсныг залруулав

### **3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Эрдэнэмандал сумын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## **4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### **1.1. Орлогын данстай холбоотой асуудал**

#### **1.1.1 Илрүүлэлт:**

Орон нутгийн 17 нэр төрлийн орлогоос 2 нэр төрлийн орлого 2,033.3 мянган төгрөгөөр тасарсан байна. Үүнд:

1. Ойн нөөц ашигласны төлбөр 842.3 мянган төгрөгөөр,
2. Нэр заагдаагүй бусад орлого 1,191.0 мянган төгрөгөөр,

Энэ нь төсвийн тухай хуулийн 41.2.1 “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

#### **1.1.2 Эрсдэл:**

- Сумын ИТХ-аар баталсан Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө орлогын нэр төрлөөр биелэгдээгүйгээс санхүүжилтийн эх үүсвэр дутагдах эрсдэлтэй байх
- Орон нутгийн Төсвийн Төвлөрүүлэн захирагчийн үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүрэг биелэгдэхгүй байх

#### **1.1.3 Өгсөн зөвлөмж:**

- Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг орлогын нэр төрлөөр жигд хангуулж ажиллах
- Орлого тасарч байгаа шалтгааныг орлогын нэр төрөл бүр дээр судлан, төлөвлөлтийг оновчтой болгох

#### **1.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Асуудлын бүртгэлээр танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

### **2.2 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ**

#### **2.2.1 Илрүүлэлт:**

Сум хөгжүүлэх сангаас олгосон 105,377.4 мянган төгрөгийн 11 зээлдэгчтэй холбоотой хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Засгийн газрын 2016 оны 153-р тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмыг зөрчсөн байна.

Эрдэнэмандал сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

#### **2.2.2 Эрсдэл:**

Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт, эх үүсвэр боломжит хэмжээнд төвлөрөхгүй байх, зарцуулалт үр дүнгүй болох улмаар найдваргүй авлага үүсэх эрсдэлийг бий болгож болзошгүй байна.

#### **2.2.3 Өгсөн зөвлөмж:**

Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг батлагдсан төлөвлөгөөний дагуу бүрэн биелүүлэхэд цаг алдалгүй дорвитой арга хэмжээ авч, Засгийн газрын 2016 оны 153-р тогтоолоор баталсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих" журмыг мөрдөж ажиллах

#### **2.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Асуудлын бүртгэлээр танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

#### **3.1. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал**

##### **3.1.1. Илрүүлэлт:**

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 126 мэдээллээс 118 мэдээллийг хугацаанд нь, 8 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

##### **3.1.2. Эрсдэл:**

Шилэн дансны тухай хууль хэрэгжихгүй байх, мэдээллийн ил тод байдал хангагдахгүй байх

##### **3.1.3. Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны тухай хуулийн 6.2.4. "хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, концессын зүйлийн жагсаалт" гэсэн заалтыг хэрэгжүүлэн мэдээллийг хугацаанд нь шилэн дансанд мэдээлж ажиллах

##### **3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Асуудлын бүртгэлээр танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 12 дугаар сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### **АУДИТЫН ТАЙЛАН**

Бэлтгэсэн: Аудитор  П.Энхжаргал

Анхан шатанд хянасан: Аудитын менежер  Т.Байгалмаа

Хоёр дахь шатанд хянасан: Тэргүүлэх аудитор Д.Уламбаяр

АРА-2021/7/СТА-ТТЗ

18

**5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

<b>Огноо:</b>	<b>Аудитын нэр:</b>	Эрдэнэмандал сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудит	<b>Аудитын код:</b>
2021			АРА-2021/7/СТА-ТТЗ
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>	Эрдэнэмандал сумын ТЕЗ		<b>Сая төгрөгөөр</b>

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны		
			Нэр	Албан тушаал	Овог нэр	
1	Орон нутгийн 17 нэр төрлийн орлогоос 2 нэр төрлийн орлого 2,033.3 мянган төгрөгөөр тасарсан байна.	2,033.3	Зөвлөмж хүргүүлэв	Засаг Санхүү дарга	дарга, албаны	Н.Лхагвадорж, Д.Ичинхорол
2	Сум хөгжүүлэх сангаас олгосон 105,377.4 мянган төгрөгийн 11 зээлдэгчтэй холбоотой хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байна.	105,377.4	Зөвлөмж хүргүүлэв	Засаг Санхүү дарга	дарга, албаны	Н.Лхагвадорж, Д.Ичинхорол
3	Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 126 мэдээллээс 118 мэдээллийг хугацаанд нь, 8 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.		Зөвлөмж хүргүүлэв	Засаг Санхүү дарга	дарга, албаны	Н.Лхагвадорж, Д.Ичинхорол
	<b>Дүн</b>	107,410.7				